

АЛБАН ТУШААЛЫН ТОДОРХОЙЛОЛТ

I. ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ

Албан тушаалын тодорхойлолтыг боловсруулсан үндэслэл:

- ☐ Төрийн албаны тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбогдуулан шинэчлэн боловсруулсан
☒ Хууль тогтоомжоор байгууллагын чиг үүрэгт өөрчлөлт орсон

Холбогдох хууль тогтоомжийн нэр, огноо:

Дагаж мөрдөх огноо:

Албан тушаалын тодорхойлолтыг
баталсан огноо:

Байгууллагын нэр:

"Замын-Үүд" чөлөөт бүсийн Захирагчийн
ажлын алба

Нэгжийн нэр:

Дэд бүтцийн хөгжил, газрын харилцааны
хэлтэс

Албан тушаалын нэр:

Дэд бүтцийн хөгжил, газрын харилцааны
хэлтсийн дарга

Албан тушаалын ангилал, зэрэглэл:

Ахлах түшмэл, ТЗ-4

Ажлын цаг:

Ажлын өдрийн 8 цаг

Ажлын байрны албан ёсны байршил:

Улаанбаатар, Чингэлтэй дүүрэг,
Самбуугийн гудамж, 4-р хороо, Засгийн
газрын XI байр /Дорноговь аймгийн
Замын-Үүд сум, Замын-Үүд чөлөөт бүс/

Хөдөлмөрийн нөхцөл:

Хэвийн

Онцгой нөхцөл:

Хамаарахгүй

II. АЛБАН ТУШААЛЫН ЗОРИЛГО, ЗОРИЛТ, ЧИГ ҮҮРЭГ

Албан тушаалын зорилго:

Чөлөөт бүсийн тухай хуулийн хэрэгжилтийг хангах, эдийн засгийн хамтын ажиллагааны
бүсийн хөгжлийн ерөнхий төлөвлөгөөний дагуу чөлөөт бүсийн дэд бүтэц, бүтээн
байгуулалт, газрын харилцааны үйл ажиллагааг зохион байгуулах, хяналт тавих, чиг
үүргийг хэрэгжүүлж, гүйцэтгэлийн үр дүнг Захирагчийн өмнө хариуцна.

Албан тушаалын зорилт:

1.Эдийн засгийн хамтын ажиллагааны бүсийг хөгжүүлэх, хөгжлийн ерөнхий төлөвлөгөө, хэсэгчилсэн төлөвлөгөөний дагуу бүсийн нутаг дэвсгэрт шинээр барих, өргөтгөх, шинэчлэх барилга байгууламж, дэд бүтцийн чиглэлээр тусгагдсан бүсийн хот төлөвлөлт, цахилгаан эрчим хүч, дулаан хангамж, усан хангамж, газар зохион байгуулалтын ажлын хэрэгжилтийг хангуулж үр дүнг тооцох, удирдлагыг мэдээллээр хангах;

2.Гаднын хөрөнгө оруулагчдыг татах замаар чөлөөт бүсийг хөгжүүлэх, төсөвт хөрөнгө төвлөрүүлэх, хөрөнгө оруулалтыг концессоор хийх боломж бүрдүүлэх;

3.Чөлөөт бүсийн нутаг дэвсгэрт шинээр барих, өргөтгөх шинэчлэх барилга, байгууламж, инженерийн шугам сүлжээний угсралт, их засварын ажлыг эхлүүлэх, үргэлжлүүлэх зөвшөөрлийг олгох ажлыг зохион байгуулах;

4.Хуульд заасан бусад чиг үүргийг хэрэгжүүлэх.

Зорилт	Албан тушаалын гүйцэтгэх чиг үүрэг	Гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлт	Хариуцлага, оролцооны хэлбэр Туслах - Т, Хариуцан гүйцэтгэх - Г Хянах - Х Шийдвэрлэх - Ш
1 дүгээр зорилтын хүрээнд	1.Хамтын ажиллагааны бүсийн хөгжлийн ерөнхий төлөвлөгөөг хэрэгжүүлэх ажлын хүрээнд хот байгуулалтын баримт бичиг, төсөл хөтөлбөр боловсруулах ажлыг мэргэжил, арга зүйн удирдлагаар хангах;	Чөлөөт бүсийг хөгжүүлэх ерөнхий төлөвлөгөөний хэрэгжилт хангагдсан байна.	Г, Х
	2.Чөлөөт бүсийн цэвэр усан хангамж, шугам сүлжээний ашиглалтын хэвийн ажиллагааг хангуулах, өвөлжилтийн бэлтгэл ажил болон гэнэтийн аваар ослыг шуурхай арилгуулах ажлыг удирдлагаар хангах;	Чөлөөт бүсийн цэвэр усан хангамж, шугам сүлжээний ашиглалтын хэвийн үйл ажиллагаа хангагдсан байна.	Г, Х
	3.Чөлөөт бүсийн усан хангамжийн бодлогыг тодорхойлоход холбогдох байгууллагуудтай хамтран ажиллаж ус хангамжийн шугам сүлжээ барих, бага оврын цэвэрлэх байгууламж өргөнөөр нэвтрүүлэх ажлыг зохион байгуулна;	Чөлөөт бүсийн цэвэр усан хангамж, шугам сүлжээ цэвэрлэх байгууламж хэвийн үйл ажиллагаагаар хангагдсан байна.	Г, Х, Ш
	4.Хамтын ажиллагааны бүсийн ерөнхий төлөвлөгөөний дагуу баригдах барилга байгууламжийн цахилгаан хангамж, төвлөрсөн болон хэсэгчилсэн, бие даасан байдлаар цахилгаан эрчим хүчээр хангах ажлын хэрэгжилтэд хяналт тавих;	Чөлөөт бүс нь цахилгаан хангамж найдвартай саадгүй эрчим хүчээр хангагдсан байна.	Г, Х

	5.Төрөөс хот байгуулалт, газрын харилцааны асуудлаар гаргасан хууль тогтоомжийн биелэлтийг хангуулах, чөлөөт бүсийг хөгжүүлэх ерөнхий төлөвлөгөө, бүсийн газар зохион байгуулалтын ерөнхий болон тухайн жилийн төлөвлөгөөг үндэслэн газрын харилцаа, газар зохион байгуулалтыг удирдлагаар хангаж, газрын бүртгэл, хяналтыг сайжруулах.	Холбогдох хууль тогтоомжийн хэрэгжилт хангагдсан байна.	Г, Х, Ш
2 дугаар зорилтын хүрээнд	1.Чөлөөт бүс дэх төрийн байгууллага, хөрөнгө оруулагчдын зөвлөл, аж ахуйн нэгжийн үйл ажиллагааг уялдуулан зохицуулахад Захирагчид мэргэжил, арга зүйн туслалцаа үзүүлэх, шаардлагатай уулзалтуудыг зохион байгуулах, холбогдох шийдвэрийг гаргахад дэмжлэг үзүүлэх;	Чөлөөт бүсэд хөрөнгө оруулалт, төсөвт төвлөрүүлэх хөрөнгө нэмэгдсэн байна.	Г, Х
	2.Чөлөөт бүсэд үйл ажиллагаа явуулах сонирхол бүхий хөрөнгө оруулагчдын бүртгэл, судалгааны сан бүрдүүлэх;	Хөрөнгө оруулагчдын бүртгэл, судалгааны сан бүрдсэн байна.	Г, Х
	3.Төсвийн хөрөнгөөр хэрэгжүүлэх хөрөнгө оруулалтын төсөл арга хэмжээ, хот байгуулалтын талаарх саналыг салбар, үйл ажиллагааны чиглэлээр гаргахад санал өгөх.	Чөлөөт бүсийн төлөвлөлт төсөл хөтөлбөрүүдтэй уялдсан байна.	Г
3 дугаар зорилтын хүрээнд	1.Чөлөөт бүсийн нутаг дэвсгэрт шинээр барих, өргөтгөх, шинэчлэх барилга байгууламж, инженерийн шугам сүлжээний угсралт, их засварын ажлыг эхлүүлэх, үргэлжлүүлэх зөвшөөрөл олгох ажлыг удирдлагаар хангах санал өгөх, хяналт тавих;	Чөлөөт бүсийн нутаг дэвсгэрт шинээр барих, өргөтгөх, шинэчлэх барилга, байгууламж, инженерийн шугам сүлжээний угсралт, их засварын ажил стандарт шаардлагын дагуу хийгдсэн байна.	Г, Х
	2.Чөлөөт бүсийн газрын харилцаатай холбоотой баримт бичгийг боловсруулж чөлөөт бүсийн нутаг дэвсгэрт иргэн, аж ахуйн нэгж байгууллагад газар эзэмших, ашиглах зөвшөөрөл олгох ажлыг зохион байгуулах, хяналт тавих;	Хөтөлбөр төлөвлөгөөний дагуу зөвшөөрөл олгогдсон байна.	Г, Х, Ш
	3.Чөлөөт бүсийг орчин үеийн өндөр технологитой нэгдсэн	Чөлөөт бүсийн нутаг дэвсгэрт шинээр барих,	Г, Х

	дулаан хангамж, цахилгаан хангамж, усан хангамж, ариутгах татуургын байгууламжийг цогцоор нь шийдвэрлэх, ногоон, тогтвортой хөгжлийн үзэл баримтлалд нийцсэн үйлдвэр, үйлчилгээ, барилга байгууламжийг төлөвлөх, байгаль орчинд ээлтэй дэвшилтэд техник технологийг нэвтрүүлэх.	өргөтгөх, шинэчлэх барилга, байгууламж, инженерийн шугам сүлжээний угсралт, их засварын ажил стандарт шаардлагын дагуу хийгдсэн байна.	
4 дүгээр зорилтын хүрээнд	1.Цаг үеийн шаардлагатай ажлын хэсэгт орж ажиллах;	Шаардлагатай холбогдох ажлын хэсгийг удирдлага зохион байгуулалтаар хангаж ажилласан байна.	Г
	2.Холбогдох хурал, семинар, зөвлөгөөнд оролцох, зохион байгуулах;	Чиг үүргийн дагуу холбогдох хурал семинар, зөвлөгөөнд оролцсон, зохион байгуулсан байна.	Г, Х
	3.Нэгжийн гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлтийг хангуулах, албан хаагчидтай гүйцэтгэлийн төлөвлөгөө байгуулж ажиллах, үр дүнг зохих журмын дагуу дүгнэх.	Албан хаагчдын гүйцэтгэлийн зөрүүг арилгах арга хэмжээ авсан байна.	Г, Х, Ш

III.АЛБАН ТУШААЛД ТАВИГДАХ ТУСГАЙ ШААРДЛАГА

Боловсрол	Бакалавр ба түүнээс дээш боловсролын зэрэгтэй.		
Мэргэжил	-хот, бүс нутгийн менежмент /041309/; -архитектур, хот төлөвлөлт /073101, 073102, 073103, 073106, 073107/; -иргэний ба үйлдвэрийн барилга байгууламж /073201-073205, 073207/.		
Мэргэшил	Төрийн албан хаагчийн дунд хугацааны сургалтад хамрагдаж, төгссөн байх.		
Туршлага	-Төрийн албанд 6-аас доошгүй жил, үүнээс дэс түшмэлийн албан тушваалд 3-аас доошгүй жил ажилласан байх; -Хөгжлийн бэрхшээлтэй иргэний хувьд төрийн албанд 3-аас доошгүй жил ажилласан байх.		
Ур чадвар	Удирдан зохион байгуулах	- хариуцсан нэгжийн үйл ажиллагааг зохион байгуулж, гүйцэтгэлийг дүгнэж, шаардлага тавьж чаддаг байх; - удирдлагадаа байгаа албан хаагчдын ажил үүргийг оновчтой хуваарилах, удирдах; - албан хаагчдын ажлын гүйцэтгэлд өдөр тутам хяналт тавьж, зохио заавар чиглэл өгөх; - байгууллагын бодлогын баримт бичиг боловсруулах; - байгууллагын нэгж хоорондын үйл ажиллагааг уялдуулан зохицуулж, гүйцэтгэлийг нэгтгэн дүгнэх, тайлагнах;	

		- нэгжийн үйл ажиллагааг зохион байгуулж, гүйцэтгэлийг дүгнэж, шаардлага тавьж чаддаг байх; - нэгжийн албан хаагчдын ажил үүргийг тэнцвэртэй, оновчтой хуваарилах; - албан хаагчдын ажлын гүйцэтгэлд өдөр тутам хяналт тавьж, зохих заавар чиглэл өгөх; - албан хаагчдын санал, бодлыг сонсох, бүтээлч санаачилга, зөв хандлагыг дэмжих; - бусад.
	Дүн шинжилгээ хийх	- чөлөөт бүсийн салбарын шаардагдах мэдээллийг цуглуулж, дүгнэх; - шийдвэрийн төслийн шууд болон шууд бус үр дагаврыг үнэлж, шийдлийн хувилбарын талаар зөвлөх; - чөлөөт бүсийн салбарын бодлогын боломжит хувилбар, зураглал гаргах; - чөлөөт бүсийн салбарын бодлогын шинжилгээний чанарын болон тоон аргууд ашиглах; - чөлөөт бүсийн салбарын судалгаанаас гарсан үр дүнг тухайн сэдвээр өмнө хийсэн судалгааны ажлын үр дүнтэй харьцуулж дүгнэлт гаргах; - чөлөөт бүсийн салбарын судалгааны дүн, мэдээлэлд тулгуурлан санал, бодлогын зөвлөмж боловсруулах; - чөлөөт бүсийн салбарын тулгамдсан асуудал, нөхцөл байдалд дүн шинжилгээ хийн бодлогын зөвлөмж боловсруулах; - бусад.
	Асуудал шийдвэрлэх	- Монгол Улсын Үндсэн хууль, бусад хуулийг чандлан баримталж, үндэсний язгуур ашиг сонирхолд захирагдан ард түмэндээ үйлчилж, төрд чин үнэнчээр зүтгэх; - албан тушаалын бүрэн эрхийн хүрээнд аливаа асуудлыг хууль болон ёс зүйн зарчимд нийцүүлэн ашиг сонирхлоос ангид шийдвэрлэх; - мэдээлэл, мэргэшлийн зөвлөгөөнийхөө үндэслэл, үнэн зөв байдлын үр дагаврыг хариуцах; - аж үйлдвэрийн өмчийн эрхийн хамгаалалтын салбарын тулгамдсан асуудлыг шийдвэрлэх хувилбарыг боловсруулж, түүний зөрөг, сөрөг үр дагаврын талаар удирдлагад танилцуулах; - аж үйлдвэрийн өмчийн эрхийн хамгаалалтын салбарын тулгамдсан асуудлыг шийдвэрлэх эдийн засаг, хууль зүйн үндэслэлийг тодорхойлох; - удирдлагын өгсөн чиглэлийн дагуу аж үйлдвэрийн өмчийн эрхийн хамгаалалтын салбарын бодлогыг хэрэгжүүлэх тодорхой арга хэмжээг зохион байгуулах; - бусад.
	Манлайлах	- ёс зүйгээр хамт олноо манлайлан үлгэр дуурайл үзүүлэх; - ажил хэргийн хувьд бүтээлч санаачилгатай ажиллах; - байгууллагын үйл ажиллагааны шинэтгэлийн үзэл санааг хамт олондоо итгүүлэн ойлгуулах, хэрэгжүүлэх; - нэгжийн үйл ажиллагаанд шинэлэг санаа үйлчилгээг нэвтрүүлэх, чиглүүлэх, албан хаагчдын шинэ санаачилга, бүтээлч хандлагыг дэмжих; - хувийн зохисон байгуулалтын хувьд үлгэр дуурайл үзүүлэх.

	Бусад	- албан хэрэг хөтлөх, баримт бичиг боловсруулах; - мэргэжлийн үйл ажиллагаа явуулахад шаардагдах компьютерын программ, мэдээллийн дэвшилтэт технологи ашиглах; - аж үйлдвэрийн өмчийн эрхийн хамгаалалтын салбарт хүний эрхийн стандартыг хэрэгжүүлэх; - төрийн албанд ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх; - онлайн харилцааг ашиглан мэдээлэл солилцох, мэдээллийг шуурхай хүргэх; - харилцагчийн үйлчилгээний удирдлагыг хэрэгжүүлэх; - англи хэл, эсхүл бусад гадаад хэлээр албан тушаалын чиг үүрэгт хамаарах мэдээллийн эх сурвалжийг ашиглах.
--	-------	--

IV.АЛБАН ТУШААЛТНЫ ХАРИЛЦАХ СУБЪЕКТ

Албан тушаалыг шууд харьяалан удирдах албан тушаалын нэр: "Замын-Үүд" чөлөөт бүсийн Захирагч.

Албан тушаалд шууд харьяалан удирдуулах албан тушаалын нэр, тоо:

1. Ахлах мэргэжилтэн-1;
2. Мэргэжилтэн-2.

Нийт: 3

Бусад харилцах субъект:

- 1.Шадар сайдын ажлын алба, төрийн захиргааны төв байгууллага, нутгийн захиргааны байгууллагын холбогдох албан тушаалтан;
- 2.Төрийн бус байгууллага, олон улсын байгууллага, төсөл, хөтөлбөрийн ажилтан;
- 3.Иргэн, хуулийн этгээд, мэргэжлийн байгууллага.

V.АЛБАН ТУШААЛЫН ТОДОРХОЙЛОЛТЫН БАТАЛГААЖУУЛАЛТ

Албан тушаалын тодорхойлолтыг боловсруулсан:

Албан тушаалын тодорхойлолтыг хянаж, батлах зөвшөөрөл олгосон байгууллагын шийдвэр:

Албан тушаал:

ЗАХИРАГЧИЙН АЖЛЫН АЛБАНЫ ДАРГА

 *Д.Дамдинцэрэн*

2025 оны 9 дугаар сарын 5-ны өдөр

Байгууллагын нэр:

ТӨРИЙН АЛБАНЫ ЗӨВЛӨЛ

Шийдвэрийн огноо:

Дугаар:

25 09 16

370

Албан тушаалын тодорхойлолт баталсан:

Байгууллагын нэр: "ЗАМЫН-ҮҮД" ЧӨЛӨӨТ БҮСИЙН ЗАХИРАГЧИЙН АЖЛЫН АЛБА

Шийдвэрийн огноо: Захирагчийн 2025 оны 10 сарын 07 өдрийн захирамж

Дугаар: А/57

(тамга/тэмдэг)

ЗАХИРАГЧ

Д.ДАМДИНЦЭРЭН

2025 оны 10 дугаар сарын 07 ны өдөр